



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2024.04.01 № 13

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангах зорилтын хүрээнд уг хөтөлбөрийн 3.5.1.2-т “Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлж, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина” хэмээн тусгасан билээ.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдийг томилсонтой холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Засгийн газраас хэрэгжүүлэх үндсэн дөрвөн зорилтоо танилцуулж, хэлсэн үгэндээ “эрчим хүчний нийт хэрэглээнийхээ 25 хувийг гаднаас авч, үүнд жилд дунджаар 140 сая ам.доллар зарцуулж буй өнөөгийн байдлыг халахын тулд “Тавантолгойн цахилгаан станц, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийг яаралтай дуусган, V цахилгааны станцын ажлыг эхлүүлэх болно” хэмээн мэдэгдсэн.

Үүнтэй холбоотойгоор 2021 оны хавар Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын гүйцэтгэгчийг тодруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр болоод байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1–т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг хийх явцад болон бүрэн ашиглалтад орсны дараа байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, судалгааны тайланг олон нийтэд нээлттэй, ил тод хэрхэн танилцуулах талаар;
2. Нөлөөллийн бүсэд хамрагдаж өрж буй зарим айл өрх, иргэдэд нөхөн олговор олгох чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, аялал

2020000143

жуулчлалын яам болон бусад холбогдох байгууллагууд хэрхэн анхаарч байгаа талаар;

3. Усны тухай хуульд эрчим хүчний зориулалтаар ус ашиглах талаарх зарим зохицуулалтыг илүү сайжруулах, ус ашигласны төлбөрийг одоо байгаа 2 хувиас нэмэгдүүлэх, Усан цахилгаан станц байгуулагдах аймаг, сумын иргэд, аж ахуйн нэгжийн эрчим хүчний үнэ тарифыг хямдруулах буюу үндсэн өртгөөр нь тооцон дэмжлэг үзүүлэх эрх зүйн ямар орчин бүрдүүлэх боломжтой талаар тодорхой хариулт ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ

2020000143